

БАТЛАВ
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГ


Н.МӨНХЗУЛ

**ИЖ БҮРЭН СИЙЛБЭРТЭЙ ГЭР БОЛОН ГЭРИЙН
ТАВИЛГА ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2024 оны 07 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Зорилго

Худалдан авах иж бүрэн гэр болон гэрийн тавилга нь монгол үндэсний уламжлалт сийлбэр, хээ, угалзтай байх бөгөөд гадаад, дотоодын зочид төлөөлөгчдөд монгол гэрийн онцлог, соёлын өвийг сурталчлан таниулахуйц байна.

Хоёр. Худалдан авах бараа

- Монгол үндэсний уламжлалт 8 ханатай гэр;
- 8 ханатай гэрийн тавилга (2 ш гэрийн иж бүрэн);
- 10 ханатай гэрийн тавилга;

Гурав. Ерөнхий шаардлага

- Гэрийн мод болон тавилгын мод нь нягтрал сайтай хуурай мод байна.
- Тооно, унь, багана, хаалга нь цэвэр модны өнгөөрөө, өөр дээрээ хагас сийлбэртэй, зориулалтын лакаар өнгөлсөн байна.
- Гэрийн тавилга (10 ханатай, 8 ханатай) бүр нь цэвэр модны өнгөөрөө, өөр дээрээ хагас сийлбэртэй, зориулалтын лакаар өнгөлсөн байна.
- Сийлбэр нь монгол хээ угалзны утга бэлгэдлийг тусгасан байна.
- Гэр болон гэрийн тавилга дээрх хээ угалз бэлгэдэл нь ямар нэгэн шашны агуулгагүй байна.

Дөрөв. Худалдан авах барааны иж бүрдэл

Д/Д	Иж бүрдэл нэр	Тоо хэмжээ	Тайлбар
8 ханатай гэр			
1	Тооно	1 ш	
2	Унь	1 ком	Унины сагалдаргыг малын гаралтай үс ноосоор хийсэн байна.
3	Багана	2 ш	
4	Хаалга	1 ш	
5	Хана	1 ком	Хар модоор хийсэн байна.
6	Өрх	1ш	
7	Гадуур бүрээс	1ш	Сайн чанарын цагаан бүрээс байх бөгөөд халзтай байна.
8	Дотуур цагаан бүрээс (цаваг)	1 ш	Дээвэр, туурга орсон бүтэн байна.

9	Хаяавч	1 ш	
10	Дээвэр туурга	1 ш	Гадна талын бороо усны хамгаалалттай, дунд хэсэгт нь зулхайтай, дотор хэсэг нь даавуун дотортой байна.
11	Дээвэр туурга	1 ком	Үйлдвэрийн цагаан эсгий дээвэр туурга байна.
12	Брезентэн дээвэр туурга	1 ком	Сайн чанарын ус нэвтэрдэггүй брезенттэй байна.
13	Бүслүүр (уяа, оосор)	1 ком	<ul style="list-style-type: none"> - Гэрийн өрх, тоононы нь даруулга болон бэхэлгээний уяанууд нь малын үс ноосоор сүлжиж томсон байна. - Бүслүүр болон бэхэлгээний уяануудыг сайн чанарын материалаар хийсэн байна.
10 ханатай гэрийн тавилга			
1	Майга ширээ	4 ш	10 ханатай гэрийн хэмжээнд нийцсэн байна.
2	Майга ширээ	1 ш	120*80*60 хэмжээтэй
3	Сандал	18 ш	Майга ширээний хэмжээнд нийцсэн байна.
8 ханатай гэрийн тавилга			
1	Авдар	2 ш	8 ханатай гэрийн хэмжээнд нийцсэн байна.
2	Майга ширээ	6 ш	8 ханатай гэрийн хэмжээнд нийцсэн байна.
3	Сандал	16 ш	Майга ширээний хэмжээнд нийцсэн байна.

---oOo---